

“ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2021 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

№ТУЗТ 11/2021

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Нийтэд санал болгох энгийн хувьцааны хэмжээг тогтоох, хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт гаргуулах, тэдгээрт холбоотой зардлын дээд хэмжээ тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1, 42.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.4, 76.1.9, 76.1.10, 76.1.18 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, 81 дүгээр зүйлийн 81.4.1, 81.4.3, 81.4.5 дахь хэсэг, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.10.12 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн хурлаас гаргасан дүгнэлт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2022-2025 онд хэрэгжүүлэх “Бизнес төлөвлөгөө 2022-2025 он”-г энэхүү тогтоолын 1-р хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн 5.4-т заасан нэг бүр нь 10 \арав\ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 19,842,125,430 \арван есөн тэрбум найман зуун дөчин хоёр сая нэг зуун хорин таван мянга дөрвөн зуун гуч\ ширхэг зарласан энгийн хувьцаанаас 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг хүртэлх энгийн хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 6.00 (зургаа) хувьтай тэнцэх энгийн хувьцааг нэмж гарган “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох замаар худалдахаар тогтоосугай.
3. Нийтэд санал болгон нэмж гаргаж буй энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгын хэмжээ нэмж гаргаж буй 10,077,100 (арван сая далан долоон мянга нэг зуу) ширхэг энгийн хувьцааны захиалгаас давсан нөхцөлд Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж дахин 5,536,868 (таван сая таван зуун гучин зургаан мянга найман зуун жаран найм) ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж гүйлгээнд гаргахаар тогтоосугай.
4. Энэ тогтоолын 1 болон 2-т заасан нийтэд санал болгох нэмж гаргаж буй энгийн хувьцааны тоо хэмжээ нийтдээ 15,613,968 (арван таван сая зургаан зуун арван гурван мянга есөн зуун жаран найм) хүртэлх ширхэг буюу Компанийн эргэлтэд гаргасан нийт энгийн хувьцааны 9.00 (ес) хүртэлх хувь байхаар тогтоосугай.
5. Компанийн эргэлтэд гаргасан хувьцааны 9.00 (ес) хүртэлх хувьтай тэнцэх 15,613,968 (арван таван сая зургаан зуун арван гурван мянга есөн зуун жаран найм) хүртэлх ширхэг энгийн хувьцааны нийтэд санал болгох нэг бүрийн үнийг Компанийн бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн андеррайтерийн компанитай харилцан тохиролцсоны үндсэн дээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д үүрэг болгосугай.
6. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргахтай холбоотойгоор андеррайтерийн компанийг сонгон шалгаруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

7. Компанийн 2020 оны 7 дугаар сарын 20-ны өдөр андеррайтерын “Эс Жи Капитал ҮЦК”-тай байгуулсан “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г цуцалсугай.
8. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргахтай холбоотойгоор 2021 оны жилийн эцсийн Компанийн бизнесийн үнэлгээг хөрөнгийн үнэлгээний “Мөнх-Оргил трейд” ХХК-иар, аудитыг “Пи Кэй Эф Монголиа” ХХК-иар, хуулийн дүгнэлтийг “Батбаяр энд Партнэрс” ХХН-иар тус тус хийлгэхээр шийдвэрлэсүгэй.
9. Энэ тогтоолын 8-т заасан бизнесийн үнэлгээ, хөндлөнгийн аудит болон хуулийн дүгнэлт хийх зардлын дээд хэмжээг 80,000,000 /наян сая/ төгрөгөөр тогтоож, холбогдох гэрээ, хэлцэл байгуулж ажиллах, тэдгээрт гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
10. Нийтэд санал болгож байгаа энгийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох, стратегийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, шаардлагатай бусад гэрээ хэлцэл байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д үүрэг болгосугай.
11. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргаж буйтай холбоотойгоор стратегийн хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх, шаардлагатай гэрээ, хэлцэл байгуулж ажиллах болон тэдгээртэй холбогдон байгуулах бүхий л гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
12. Компаниас нэмж энгийн хувьцаа гаргаж буйтай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д холбогдох журмын дагуу мэдэгдэж зөвшөөрөл авах, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хандаж холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Г.ЗОЛБОО/